**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: : ДАА-2026/106/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.Shinjlenmagadlahuiezshaudit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр<br>Утас: 70373089, 99023682<br>Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Батсүрэн<br>Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn<br>Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК<br>Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui. audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 135

танай ______________-ны №________________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН 30 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургуулийн 2025 оны нийт төсвийн зарцуулалт тайлант онд хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4529050231

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус сургуулийн цалингийн зардал 264,192.1 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 33.1 хувиар өссөн байна.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулах болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 30 дугаар сургууль нь байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилтын хүрээнд 35 арга хэмжээ төлөвлөж,хэрэгжилтийг 92.0 хув ийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР** **Ш.МӨНХБАЯР**

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**СТ-1**

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **351,135,787.48** | **567,930,752.56** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 346,296,880.41 | 563,305,840.49 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 346,296,880.41 | 563,305,840.49 |
| **3121** | **Төгрөг** | 346,296,880.41 | 563,305,840.49 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 346,296,880.41 | 563,305.840.49 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **4,838,907.07** | **4,624,912.07** |
| **351** | **Түүхий эд материал** | 225,350.00 | 30,350.00 |
| 35130 | Эм боох материал | 225,350.00 | 30,350.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **4,613,557.07** | **4,594,562.07** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 447,500.00 | 19,250.000 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,429,912.07 | 209,812.07 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,736,145.00 | 4,365.500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **113,035,912.97** | **113,896,436.90** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 113,035,912.97 | 113,896,436.90 |
| **392** | **Биет хөрөнгө** | 111,577,579.68 | 112,938,103.65 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 149,032,150.30 | 136,111,992.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (55,735,793.47) | (42,930,985.91) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,964,880.00 | 22,721,952.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,828,412.15) | (4,924,194.44) |
| 39217 | Ном | 3,144,755.00 | 1,959,340.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **1,458,333.29** | 958,333.25 |
| 39301 | Програм хангамж | 1,124,300.00 | 1,124,300.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,124,300.00) | (1,124,300.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (541,666.71) | (1,041,666.75) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **464,171,700.45** | **681,827,189.46** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **464,171,700.45** | **681,827,189.46** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 464,171,700.45 | 681,827,189.46 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 36,180,641.27 | 36,180,641.27 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 36,180,641,27 | 36,180,641,27 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 427,991,059.18 | 645,646,548.19 |
| 651210 | Өмнөх үеийн үр дүн | 427,991,059.18 | 427,991,059.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 217,655,489.01 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **464,171,700.45** | **681,827,189.46** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **617,104,445.00** | **667,120,908.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,558,745.00** | **26,343,208.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,558,745.00 | 26,343,208.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,072,400.00 | 10,676,208.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,072,400.00 | 847,600.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 50,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 9,778,608.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 2,486,345.00 | 15,667,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **613,545,700.00** | **640,777,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 612,045,700.00 | 637,777,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 612,045,700.00 | 637,777,700.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,500,000.00 | 3,000,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,500.000.00 | 3,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **348,217,111.48** | **444,816,224.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **348,217,111.48** | **444,816,224.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 348,217,111.48 | 440,999,824.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 264,192,088.70 | 332,001,245.90 |
| 210101 | Үндсэн цалин | 193,077,319.43 | 219,585,748.72 |
| 210102 | Нэмэгдэл | 63,621,810.27 | 90,652,147.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 11,715,000.00 |
| 210104 | Урамшуулал | 7,492,959.00 | 10,048,350.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,625,714.41 | 39,978,990.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,621,071.15 | 28,173,963.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,451,653.85 | 3,163,233.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,225,826.94 | 1,581,616.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 987,937.93 | 1,351,494.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,339,224.54 | 5,708,682.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,939,146.79 | 8,339,350.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,687,000.00 | 3,001,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо,интернэтийн төлбөр | 81,981.79 | 16,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 392,000.00 | 838,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,093,265.00 | 3,738,950.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,684,900.00 | 744,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 619,000.00 | 195,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 277.000.00 | 195,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 342,000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,218,400.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,218400.00 | 3,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 565,000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 565,000,00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,907,760.00 | 12,316,980.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,072,400.00 | 847,600.00 |
| 210802 | Аудит,баталгаажуулалт,зэрэглэл тогтоох | 702,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл,технологийн үйлчилгээ | 3,133,360.00 | 11,469,380.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 37,150,001.58 | 45,168,259.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,456,450.00 | 7,141,654.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,227,500.00 | 8,407,115.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,446,051.58 | 29,619,490.02 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 3,816,400.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 3,816,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 3,816,400.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **268,887,333.52** | **222,304,683.06** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,408,177.50** | **4,649,194.05** |
| **225001** | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | **1,408,177.50** | **4,649,194.05** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **(1,408,177.50)** | **(4,649,194.05)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **267,479,156.02** | **217,655,489.01** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **614,618,100.00** | **641,675,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,072,400.00** | **897,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,072,400.00 | 897.600.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,072,400.00 | 897,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | **1,072,400.00** | **847,600.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | **50,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **613,545,700.00** | **640,777,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 612,045,700.00 | 637,777,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 612,045,700.00 | 637,777,700.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,500,000.00** | **3,000,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,500,000.00 | 3,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **320,865,899.90** | **414,982,739.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **320,865,899.90** | **414,982,739.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **320,865,899.90** | **411,166,339.92** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 264,192,088.70 | 332,001,245.90 |
| 210101 | Үндсэн цалин | 193,077,319.43 | 219,585,748.72 |
| 210102 | Нэмэгдэл | 63,621,810.27 | 90,652,147.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 11,715,000.00 |
| 210104 | Урамшуулал | 7,492,959.00 | 10,048,350.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,625,714.41** | **39,978,990.02** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,621,071.15 | 28,173,963.02 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,451,653.85 | 3,163,233.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,225,826.94 | 1,581,616.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 987,937.93 | 1,351,494.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,339,224.54 | 5,708,682.60 |
| **2106** | **Эд хогшил,урсгал засварын зардал** | **1,500,000.00** | **3,000,000.00** |
| **210604** | Урсгал засвар | 1,500,000.00 | 3,000.000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,205,760.00 | 12,333,480.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,072,400.00 | 847,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,133,360.00 | 11,485,880.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **19,342,336.79** | **23,852,624.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,078,836.79 | 17,654,154.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,263,500.00 | 6,198,470.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **3,816,400.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 3,816,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 3,816,400.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **293,752,200.10** | **226,692,560.08** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (5)** | **16,919,800.00** | **9,683,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **16,919,800.00** | **9,683,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 16,919,800.00 | 9,683,600.00 |
| **222001** | **Тоног төхөөрөмж** | 16,919,800.00 | 9,183,600.00 |
| **223001** | **Бусад хөрөнгө** | | **500,000.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(16,919,800.00)** | **(9,683,600.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 276,832,400.10 | 217,008,960.08 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 69,464,480.31 | 346,296,880.41 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 346,296,880.41 | 563,305,840.49 |

**СТ-4**

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| С01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **36,180,641.27** | **-** | **160,511,903.16** | **196,692,544.43** |
| С02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | **-** | **-** |
| С03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| С04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| С05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | - | - | |
| С06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| С07 | Тайлант үеийн үр дүн | - | - | **267,479,156.02** | **267,479,156.02** |
| С08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **36,180,641.27** | **-** | **427,991,059.18** | **464,171,700.45** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | **217,655,489.01** | **217,655,489.01** |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **36,180,641.27** | **-** | **645,646,548.19** | **681,827,189.46** |

**ТГ**

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 640,777,700.00 | 640,777,700.00 | | 100 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 637,777,700.00 | 637,777,700.00 | | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 637,777,700.00 | 637,777,700.00 | | 100 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3,000,000.00 | 3,000,000.00 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 3,000,000.00 | 3,000,000.00 | | 100 |
| 120004 | Төсөвт байгу уллагын үйл ажиллагаанаас | 339,169,900.00 | 897,600.00 | 338,272,300.00 | 0.26 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 847,600.00 | 847,600.00 | | 100 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,000.00 | 50,000.00 | | 100 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 338,272,300.00 | | 338,272,300.00 | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 979,947,600.00 | 641,675,300.00 | 338,272,300.00 | 65.48 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 979,947,600.00 | 424,666,339.92 | 555,281,260.08 | 43.34 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 976,131,200.00 | 420,849,939.92 | 555,281,260.08 | 43.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **822,748,500.00** | **332,001,245.90** | **490,747,254.10** | **40.35** |
| 210101 | Үндсэн цалин | 534,435,700.00 | 219,585,748.72 | 314,849,951.28 | 41.09 |
| 210102 | Нэмэгдэл | 281,916,300.00 | 90,652,147.18 | 191,264,152.82 | 32.16 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 11,715,000.00 | -11,715,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 6,396,500.00 | 10,048,350.00 | -3,651,850.00 | 157.09 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **102,843,500.00** | **39,978,990.02** | **62,864,509.98** | **38.87** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,933,600.00 | 28,173,963.02 | 41,759,636.98 | 40.29 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,227,500.00 | 3,163,233.10 | 5,064,266.90 | 38.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,113,700.00 | 1,581,616.62 | 2,532,083.38 | 38.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,113,700.00 | 1,351,494.68 | 2,762,205.32 | 32.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,455,000.00 | 5,708,682.60 | 10,746,317.40 | 34.69 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,000,000.00** | **3,000,000.00** | | **100** |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 | | 100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,889,000.00** | **12,333,480.00** | **555,520.00** | **95.69** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 847,600.00 | 847,600.00 | | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,041,400.00 | 11,485,880.00 | 555,520.00 | 95.39 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **34,650,200.00** | **33,536,224.00** | **1,113,976.00** | **96.79** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,372,800.00 | 27,337,754.00 | 1,035,046.00 | 96.35 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,277,400.00 | 6,198,470.00 | 78,930.00 | 98.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,816,400.00** | **3,816,400.00** | | **100** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,816,400.00** | **3,816,400.00** | | **100** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,816,400.00 | 3,816,400.00 | | 100 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **979,947,600.00** | **424,666,339.92** | **555,281,260.08** | **43.34** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 346,296,880.41 | -346,296,880.41 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 563,305,840.49 | -563,305,840.49 | |
| 1 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | | | | |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 16 | 16 | | 100 |
| 6 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 14 | 14 | | 100 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | | 100 |
| 11 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 264 | 264 | | 100 |
| 12 | Төрийн өмчит ЕБС | 264 | 264 | | 100 |

| 24 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | | | | |
|---|---|---|---|---|---|

ТГ

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт илэрсэн 4,752.9 мянган төгрөгийн зөрчил[1]-д 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,152.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

## 5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

1. Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн Бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал Ж.Болорцэцэгт 600.0 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 39 дүгээр тогтоолоор баталсан Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 5.2 Албан шаардлага

1. Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2. Тус сургуулийн нягтлан бодогч Ж.Дэлгэрмаа 1,401.1 мянган төгрөг, нярав Урангоо 607.7 мянган төгрөг Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, сургуулийн захирлын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны

[1] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

өдрийн Б/30 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар ”өөрчлөлтгүй” дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 1 дахин нэмэгдүүлж, 2,008.9 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсаннь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-т "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа нь нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх акт албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сургалтын төлбөрийг байгууллагаар төлүүлсэн | 1 | 600.0 | 1 | 600.0 | | | | | | | | |
| хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй | 1 | 2,144.0 | | | 1 | 2,144.0 | | | | | | |
| Балансын урамшуулал, төрийн албан хаагчийн үр дүнгийн | 1 | 2,008.9 | | | 1 | 2,008.9 | | | | | | |

.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| урамшуулалт ай давхардсан | | | | | | | | | | | | |
| ДҮН | 3 | 4,752.9 | 1 | 600.0 | 2 | 4,152.9 | | | | | | |

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймаг Дархан сумын Ерөнхий боловсролын 30 дугаар сургууль

Аудитын код: ДАА-2026/104/НА-СТА-ТШ3

Тайлант хугацаа: 2025 он

Эрсдэлтэй АГАДҮТ-н түвшинд хэрэгжүүлсэн туршилтын сорилын үр дүнг үнэлэх ажлын баримт

| № | Нөлөөлөх бүх АГАДҮТ | АГАДҮТ-н дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж засаж тооцох эсэх | Шалгуур: Стандартын заалт | Шалгуур: Хууль тогтоомжийн заалт | Алдаа, зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Ажил гүйлгээний анги | Цалингийн зардлын данстай холбоотой асуудал | Боловсролын газрын даргын 2025 оны А/84 дугаар тушаалын үндсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтанд нэмэгдэл олгож нийт 2,144,000.00 төгрөг ... хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй | 2,144,000.00 | Материаллаг | Үгүй | ҮСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга". | Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын ... үйл ажиллагаа ...", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, **хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна**". 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн нэгж, ажилтны орон тооны нормативыг ... хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална". Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1-д ... "Төрийн болон төрийн өмчит ... төсөвт байгууллага ажилтны тооноос хамааралгүйгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй нэмэгдэл олгоно" | Хууль тогтоомжийн зөрчилтэй холбоотой | Албан шаардлага хүргүүлэх | | | |
| 2 | Ажил гүйлгээний анги | Зардлын данстай холбоотой асуудал | Боловсролын байгууллагын багш ажилтныг мэргэжил дээшлүүлэх ... зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан зардал Ж.Болорцэцэгт 600,000.00 төгрөг олгосон | 600,000.00 | Материаллаг | Тийм | ҮСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга". | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийн хөрөнгийг ... зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Хувьсах зардлын хэмжээ, олголт, журам батлах тухай" 39 дүгээр тогтоолоор батлагдсан Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшуулал олгох журам" | Хууль тогтоомжийн зөрчилтэй холбоотой | Төлбөрийн акт тогтоох | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Баланс ын данстай холбоот ой асуудал | Зардлын данстай холбоо той асуудал | Тус сургуулийн нягтлан бодогч Ж.Долгормаа 1,401,151.00 төгрөг, нярав Уранчэц 607,750.00 төгрөг Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, сургуулийн захирлын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн Б/30 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны саналуулийн тайланд хийсэн аудитаар "маргаантай" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалин 1 дахин нэмэгдүүлж, 2,008,901.00 төгрөгийн урамшуулал олгосон нь, төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшууллаар давхардсан байна. | 2,008,901.00 | | | | Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөх, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4.1 "Төрийн албаны тухай хуульд тусгайлан заагаагүй шалтгаанаар төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай" "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.6-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна. | Хууль тогтоом жийн заалтай холбоо той | Албан шаард лага | | | |
| ДҮН | | | | 4,752,901.00 | | | | | | | | | | |

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг хэлэлцсэн:

Ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн [illegible] Ж.Болормаа [illegible] Огноо

Ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн нягтлан бодогч Ж.Долгормаа Огноо

Асуудлын бүртгэл хөтөлсөн:

"Шинэчлэн магадлахуй ЭЭШ аудит" ХХК-ийн [illegible] Огноо

"Шинэчлэн магадлахуй ЭЭШ аудит" ХХК-ийн аудитор [illegible] Огноо

"Шинэчлэн магадлахуй ЭЭШ аудит" ХХК-ийн аудитор [illegible] Огноо

Анхан шатны хяналт хийсэн:

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын [illegible] аудитор С.[illegible] Огноо 2026.02.24

Хоёр дахь шатны хяналт хийсэн:

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер [illegible] Огноо 2026.02.24.

Гурав дахь шатны хяналт хийсэн:

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор [illegible] Огноо 2026.02.27